

ЁС СУРТАХУУНЫ ГЕНЕАЛОГИЙН ТУХАЙ ФРИДРИХ НИЦШЕГИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТУХАЙД

Р.Дарьхүү, доктор (Ph.D), профессор
МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн зөвлөх профессор

С.Хишигтогтох, доктор (Ph.D)
МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуулийн, түүх
нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш

Товч утга. Ёс суртахууны үүсэл гарал, мөн чанарын тухай асуудал философи, ёс суртахууны судалгааны гол асуудлын нэг юм. Учир нь ёс суртахуун бол хувь хүн болон нийгмийн оюун санааны өргөн ойлголт. Ёс суртахууны мөн чанарыг ойлгохын тулд түүний гарал үүслийг судлах зайлиггүй шаардлагатай.

Бид нийтлэлдээ; ёс суртахуун нь зөвхөн нийгмийн оюун санааны үзэгдэл биш гэдгийг тайлбарлахын зэрэгцээ түүнийг хүний мөн чанарын үүднээс авч үзсэн Ф.Ницшегийн үзэл баримтлалыг шинжиллээ.

Түлхүүр үг. Ёс суртахуун, ёс суртахууны генеалог, Христийн ёс суртахуун, сүргийн ёс сурахуун, сайн ба муу, нүгэл буян, эрхэм чанар. “ressentiment”

Ёс суртахууны үүсэл, уг чанарын асуудал фило софи, ёс зүйд эртнээс эдүгээ хүртэл олон талаас судлагдсаар иржээ. Энэ удаа бид ёс суртахууны үүсэл, мөн чанарын тухай Ф.Ницшегийн үзэл баримтлалыг шинжлэн үзлээ. Тэрээр 1887 онд бичсэн “Ёс суртахууны генеалог” (*On the Genealogy of Morality*) зохиолоо бичсэн. Энэ бүтээл нь түүхэн цаг үедээ Европын соёлыг ноёрхож байсан Христийн шашны ёс суртахууны үүсэл, мөн чанарын тухай юм. Ф.Ницше, бүтээгч эзэн ба гэм буруу, шийтгэлийн тухай ойлголт дээр тулгуурлан хүнийг өөрөө өөрийгөө мэдэх эрхгүй, сүргийн амьтан болгодог шашныёс суртахуунаас яагаад татгалзах тухай өгүүлсэн. Гэвч түүний энэ бүтээл нь өргөн агуулгаараа зөвхөн Христийн шашинт нийгмийн ёс суртахууны тухай бус, ер нь хүн төрөлхтний түүхэнд дэх ёс суртахууны үүсэл гарал, мөн чанар бол тэр цаг үедээ ноёрхогч хэсгийн хүсэл зориг, дур зоргын бүтээгдэхүүн байсаар ирснийг харуулсан. Гагцхүү нийгмийн бүтцээсээ хамаарч юуг “бүхний хэмжүүр” хэмээн үзэж буйгаар ёс суртахуун янз бүрээр тодорхойлогддогийг түүний үзэл баримтлал илэрхийлдэг билээ.

Ф.Ницше, нийгэмд ноёрхлоо тогтоогч ба ноёрхлыг дагагч бүлгүүд, тэдний ёс суртахууны үүсэл, мөн чанарын асуудлыг судлахдаа боолын нийгэм болон Христийн шашинт нийгмийг жишилт, зүйрлэл болгож байв. Түүний эхний тайлбараар нийгэмд эрх мэдлийн хувьд ноёрхогч бүлэг, түүнд үнэмлэхүй захирагдмал боолын бүлэг байна. Ноёрхогч бүлэг нь нийгмийн загварыг тогтоогч юм. Тэд өөрсдийн ёс суртахууныг бататгаж байгаа бүхнийг “сайн” гэсэн ойлголтод, харин боолд хандсан бүхнийг “муу” гэсэн ойлголтод хамруулдаг тогтсон ёс байсаар ирсэн тухай тэрээр өгүүлжээ.

Боолын нийгмийн ёс суртахууны “сайн” ба “муу” гэдэг ойлголтууд бол хүний жинхэнэ ёс суртахууны үнэт чанарыг тэмдэглэдэггүй бөгөөд жам ёсны эрх чөлөөнд харш зүйлүүд ч “сайн” гэсэн үнэлэмжтэй байдаг тухай авч үзсэн. Түүний бичсэнээр; “... эздийн ёс суртахуун нь тэдний төрөлхийн мулгуу зан авираас үүд элтэй, тэдний сайны тухай үзэл баримтлал нь эрүү шүүлтийн үндэслэл болсон. Ноёрхогчдын с айн, с айхан хэмээн үнэлдэг, боолуудад тааламжгүй

үйлдлүүд нь ноёрхогч бүлэгт “ашиг тус”-ыг үзүүлжээ. Тэд өөрсдөдөө зориулж, эрхэм дээд хүчирхэг, өндөр байр суурьтай хэмээх үнэлгээг баталгаажуулж, ийм байр суурь нь доод бүлгийг дуулгавартай байх ёстой гэсэн үнэлгээг боловсруулах үндэс болов. Энэ үнэлгээ нь анхнаасаа тэдний үнэ цэнтэй байх утгуудыг бий болгож, ийнхүү үнэлэмжээ «сайн, сайхан» хэмээн нэрлэх болсон¹ гэжээ. Өөрийгөө илэрхийлэх эрх чөлөөг эдлэх, эдлэхийг оролдох нь тухайн нийгмийн хувьд “тэрс” үзэлтэн болно. Тэрс үзэлтэн нийгмийн бүтцийн хувьд шийтгэл хүлээх ёстой. Шийтгэл хүлээх нь айдаст автуулна. Айдас нь гэмшил бий болгоно. Буруутай гэсэн мэдрэмж нь шашны ойлголтоор нүглээ наманчлах, бусад хэмжүүрээр аялдан дагалдах буюу (сүрэгт нэгдэх) байдлаар хэрэгжинэ. Ийм замаар аливаа нийгэмд цөөнх эрх ашиг, хүсэл зориггоо олонход тулган хүлээлгэж хүний жам ёсны эрхийг харгисаар зөрчиж ирсэн түүхийг харуулсан байна. Ф.Ницше, өөрийн бүтээлээрээ хүний ёс суртахууны эерэг сайн чанаруудыг үгүйсгээгүй бөгөөд гагцхүү ёс суртахууны гажуудлын эсрэг үзэл баримтлалаа боловсруулжээ.

Боолын эзэн ба боолын ёс суртахууны тухай жишилтээс үзэхэд, сайн, муу, ашигтай, ашиггүй, эрхэм дээд ба дорд байх тухай ойлголт нь оршин буй нийгэм-соёлын нөхцөлөөр (тухайлбал шашнаар) тодорхойлогдож, баталгааждаг харьцангуй шинжтэйг Ф.Ницшегийн үзэл баримтлалаас ойлгож болно. Харьцангуй шинжтэй ёс суртахууны ойлголтууд нь аливаа нийгэм дэх нэг хэсгийн хувьд “үнэн”, “зөв”, “шударга”, “буян” хэмээн үнэлэгдсэн хэм хэмжээ, албадлага шаардлагуудаар хэрэгждэг. Энэ нь нийгмийн нөгөө хэсгийн эрх чөлөө, эрхэм чанарт харшилж байдаг. Эрх чөлөө, эрхэм чанар, халдашгүй дархан байдлын хувьд өөрийн боломжоо алдсан нэг хэсэг нь ноёрхогч бүлгийн албадлага, шаардлагыг дуулгавартай дагах үүрэг хүлээнэ. Дуулгавартай байхыг “үнэн”,

“зөв” ёс суртахуунтайн илрэл гэж үзэх нь хүний эрхэм чанар хүн бүрд адил тэгш байх жам ёсны эрхийг нухчин дарж, хувь хүнийг өөрийнх нь чөлөөт байдлын эсрэг хүлцэнгүй ёс суртахууныг ухамсаргүйгээр хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрддэгийг онолын хувьд гаргаж тавьснаараа Ф.Ницше гавьяатай юм.

“Дуулгавартай” байх (сүргийн) ёс суртахуун хэрхэн бий болсон бэ? гэдэг ойлголтыг Ф.Ницше мөн өгүүлжээ. Тэрээр, гэм буруугийн мэдрэмж, айдас гэсэн ойлголт гаргаж ирсэн. Эдгээр ойлголттой холбоотой “ressentiment” гэдэг франц гаралтай нэр томъёог Ф.Ницше орчуулгагүй хэрэглэсэн буй. Сэтгэл зүй, нийгмийн байр суурийн хувьд асар ялгаатай, хоёр түвшний ёс суртахууны харилцаанаас үүдэлтэй бий болдог сэтгэл зүй, зан суртахууны үзэгдлийг “ressentiment” гэдэгт багтаажээ. Түүний үзлээр, энэ үг гомдол хорсол, үзэн ядалт, хорон муу санаа, хонзон өвөрлөхийг илэрхийлдэг. Ф.Ницше “ressentiment” гэдэг ойлголтоо сул доройгоо мэдэрсэн сэтгэлийн хорсолтой холбон тайлбарлаж байв. Нийгмийн байр суурийн хувьд эрх мэдлийг тогтоон хэрэгжүүлэгч нь “ийм л байх ёстой” гэсэн дур зоргын үндэс дээр өөрийн загварыг тогтоодог. Энэхүү тогтоосон загвар бол индивидийн хувьд дарамт, шахалт болж өөрийн эрх, эрх чөлөөг үгүйсгэх цөөнхийн тогтоосон загварыг дагаж мөрдөх болно. Ингэхдээ тэд өөрийгөө мэдэх эрхгүй сул дорой байгаадаа “жинхэнэ сүрэг шиг” амьдарч буйдаа гомдол, үзэн ядалт өвөрлөдөг. Үзэн ядалт, гомдол тээгч нь хэзээд эсэргүүцэл үзүүлэх (тэрслэх)-эд бэлэн байдаг. Гэвч тэд айдаг, юунаас айдаг вэ?.

Боолын нийгэмд “эзний шийтгэлээс” айдаг байв. Ф.Ницше “ressentiment”-ийн хоёр үндсэн хэлбэр байдаг, нэгдүгээрт, бусад руу хандсан “ressentiment”² Бусад руу хандсан гомдол гэдгийг тэрээр боолуудын бослогын жишээгээр тайлбарласан.

¹ Ф.Ницше. К генеалогии морали- Сочинения в двух томах. Т.1, М., 1990, с. 416.

² Ф.Ницше. К генеалогии морали- Сочинения в двух томах. Т.1, М., 1990, с. 424-427.

Түүний зүйрлэлээр, “эзэд өөрсдийн ёс суртахууны үнэлэмжийг тогтоож, боолыг удаан хугацаанд дарангуйлсан нь тэдэнд гомдлын мэдрэмж бий болгоно. Тэр гомдол нь өшөө хорслын эх үндэс болж, эзэд рүүгээ бослого гаргаж, тэднийг тооны олноор дарах хонзонт ёс суртахууныг үүсгэдэг. Эздийн эсрэг боолууд бослого гаргаж, тэдний тогтоосон ёс суртахууныг зөрчиж гэм хийсний төлөөх шийтгэлийг хүлээх болно. Энэ нөхцөлд “гэмтэй” байх тухай ойлголтоор дамжин шийтгэлээс айх айдас боолуудыг сэтгэл зүйн хувьд сул дорой болгож хувиргадаг.³ Ийнхүү сул доройн мэдрэмж бүхий ёс суртахууны тухай ойлголтыг Ф.Ницше өөрийн үзэл баримтлалдаа боловсруулж, түүнийгээ “сүргийн ёс суртахуун” гэж нэрлэсэн байна.

Хүний нийгмийн түүхэн нөхцөлийг харахад хөгжлийн явцад янз бүрийн айдас байсаар ирсэн. Дундад зууны үед “нүгэл хийсэн гэх” буруутгалаас, коммунизмын үед “үзэл суртлын эсрэг” гэх шийтгэлээс харин ардчилсан гэх өнөөгийн нийгэмд шууд ба шууд бус алагчлалаас, тогтсон хэм хэмжээнээс өөр байхаас айдаг. Өөрийн эрхээр бус хүний эрхээр үйлдэж буй хүнээс ёс суртахууны “сайн” “буян” гэх ойлголтоор илэрхийлэх зан авир гардаггүй гэж Ф.Ницше үзсэн юм. Учир нь тэд гомдол, өс тээгч болон хувирсан байдаг тухай өгүүлж байв.

“Бурхан тэнгэр бол нүглийн эцэг мөн, яагаад гэвэл христ шашин нүглийн тухай ойлголтоор дамжуулаад хүмүүсийг сул дорой, өөрийгөө мэдэх эрхгүй, дээрээс тогтоочихсон дүрэм журам зөрчихөөс айдаг болгодог. Энэ шашнаар хүмүүжсэн, үүнийг удирдлагаа болгож байгаа хүн бол хэзээ ч эрх чөлөөтэй байж чадахгүй, хэзээ ч өөрийнхөө мөн чанарыг мэдрэхгүй, хүний өөрт нь байх эрхэм чанар, өөрийгөө мэдэх тэр эрхийг дарж, үгүй болгодог”⁴

гэж Ф.Ницше үзэж байв. Бурхан тэнгэрийн өмнө гэмтэй гэх сэтгэл зүй бол хүнийг өөрийн эрхээр байхыг хязгаарладаг, гэм буруугийн мэдрэмжээр дамжуулж жинхэнэ үнэн мөнөөр өөрийгөө олох эрхийг үгүй хийдэг учир Ф.Ницшегийнхээр бурхан тэнгэр нүгэлтэй аж. Жишээ дурдахад 1990-ээд оны эхээр Христэд итгэгч бүлэг олноор үүсэж, энэ нүгэлт ертөнцөөс ангижирч өөр шинэ ертөнцөд очих тухай итгэл үнэмшил хүүхэд залуучуудын сэтгэл зүйд хүчтэй нөлөөлж, өндрөөс унах зэрэг үзэгдэл гарч байсныг ийнхүү тайлбарлаж болох буй за.

Ф.Ницше “Христэд тэрслэгч” зохиолдоо “... өөрсдийгөө, нийгэмлэгээ, энэрэнгүй шударга гэж үзсэн хүмүүсээ тэд (Христ шашинтнууд) нэг талд буюу “үнэний” талд, бусад бүхэн буюу (Ертөнцийг) нөгөө талд тавьжээ. Энэ бол газар дэлхий дээр өнөөг хүртэл оршиж байсан биеэ өргөмжлөх бүх өвчний дотроос хамгийн лайтай нь байсан юм”.⁵ гэжээ. “Өөрсдийгөө өргөмжлөх бүх өвчин” гэсэн нь христийн шашнаас өөр мөн ийм хэмжээний эрх дархаар өвчилсөн бурангуй үзэл баримтлал хүн төрөлхтний түүхэн оршсоор ирснийг харуулж буй юм. Ф.Ницшегийн үзлээр, өөрсдийгөө өргөмжилдөг шашны бүлэг, тэдэнд дуулгавартай захирагддаг нөгөө бүлэг гэсэн хоёр давхраа нийгмийн сэтгэл зүйн үндсийг бүрдүүлж, энэ нь цаашдаа нийгэм соёлын бүтцийг тодорхойлж, улам бүр бэхэждэг. Тиймээс итгэл үнэмшил бол байнга айдас, хараат байдалд хүнийг оруулдаг бөгөөд харин бурхан тэнгэрийг шүтэхгүйгээр хувь заяагаа хүн өөрөө тогтоосон нь бодит үнэнд нийцнэ гэж тэрээр үзэж байв.

“Эмгэнэлт жүжгийн үүсэл буюу Эллин ёс ба гутрангуй үзэл” зохиолдоо Ф.Ницше “...эзэн тэнгэрийн тухай ойлголт гажуудсан, ёс суртахууны тухай ойлголт гажуудсан: еврей тайлгачид үүгээр хязгаарласангүй”⁶ гэжээ. Ёс суртахууны

³ Ф.Ницше. К генеалогии морали- Сочинения в двух томах. Т.1, М., 1990, с. 424-427.

⁴ Мөн тэнд с.424-427.

⁵ Ф.Ницше. Эмгэнэлт жүжгийн үүсэл буюу эллин ёс ба гутрангуй үзэл. Христэд тэрслэгч. Орч. О.Чимэг, УБ., 2012, 232 дахь тал.

тухай ойлголт хүний мөн чанараас өөрөөс нь ангид, зохиомол болж гажуудсан нь бурхан тэнгэрийн тухай ойлголтоор дамжуулж, бүхнийг өөрийн эрхшээлдээ оруулдаг Христ шашнаас болж байна гэсэн утгатай. Түүний үзлээр, шашин бол бүхэл том зохион байгуулалт (институт) болж оршдог учир нийгмийг өөрийн ёс суртахуунаар удирдаж чаддаг тухай бичиж байсан.

Алив аа нийгэмд тогтсон ёс сурт ахууныг нийгмийн гишүүд албадлагаар, итгэл үнэмшлээр зэрэг захирагдаж, дагаж мөрддөг. Ф.Ницшегийн хувьд ийм тогтолцоо нь нийгэм хөгжихийн хирээр нарийн нийлмэл болж, хувь хүнийг улам бүр эрхшээлдээ оруулах юм гэсэн санааг илэрхийлсэн нь хожим М.Фукогийн “эрх мэдлийн генеалогийн” үзэл баримтлалын үндэс болсон байдаг. Нийгмийн шаардлага дарангуйллын шинжтэй болж хувирахад түүний эсрэг хүмүүс эрх чөлөөгөө хамгаалахаар тэмцдэг байсан тухай Ф.Ницше боол ба эзэн хоёрын ёс суртахуунаар зүйрлэн илэрхийлсэн. Эзний дарангуйллын эсрэг боссон ч ноёрхлыг эвдэж чадаагүй, бослого гаргасныхаа төлөө боол “гэм буруутай” болдог. Иймээс гэм буруугийн мэдрэмж, шийтгэл хүлээх айдас зэргээс болж эзэнд дуулгавартай захирагдах ёс суртахууны үндэс бэхжин тогтдог. Ийм тохиолдолд өөрийн эрх чөлөөнөөс дээгүүр орших нийгмийн ёс суртахууны зарчим, хэм хэмжээг дагаж баримтлах замаар хувь хүн өөрийн эрхэм чанар, эрх чөлөөг орхих болдог.

Ф.Ницшегийн энэхүү шүүмжлэл нь христ шашинт нийгэмд илүүтэй хандсан билээ. Яагаад христ шашинд шүүмжлэлтэй хандсан тухайд; шашин гэдэг нь өөрөө сүм хийд, сүм хийд бол тогтолцоо, тогтолцоо нь лам хуврагуудын гарт ороод, лам хуврагууд асуудлыг шийдээд ирмэгц, өөрт эвтэй байдлаар Есүс христийн номлолыг урвуулан ашиглаж,

энгийн ардыг оюун санааны хүлээсэнд байлгахыг зорьдог болсон гэж үзэж байв. Үүнээс дүгнэхэд Есүс христийн нэрийн дор ямагт бурхан тэнгэрийн өмнө буруутай мэт гэм буруугийн мэдрэмжид хүлэгдсэн номхон хүлцэнгүй шашны ёс суртахууныг шүүмжилсэн хэрэг юм.

Хүн өөрөө өөрийгөө мэдэх гэдэг тэр эрхийг христ шашны зохиомол ёс суртахуун дарж байна гэж тэрээр үзэхдээ Ф.Ницше “... гагцхүү бие даасан хувь хүн л өөрийгөө танин мэдэж, сул дорой хүний айдас түгшүүртэй, ёс суртахуунаас ангижирч, өөрийн мэдрэмжийг сонсож чадах болно. Ийм хүн өөрийн гэсэн хүсэлтэй, зоригтой амлалт өгч чаддаг ба ёс суртахууны хариуцлага хүлээж чаддаг. Зөвхөн ийм үүрэг хариуцлага нь хүнийг эрх чөлөө, өөртөө итгэх итгэлийг бий болгоход хүргэдэг. Ийнхүү бие даасан, эрх чөлөөт хүн хэн нэгнээс хамааралтай хүнээс илүү ёс суртахуунд ойрхон юм. Түүнд ёс суртахууны хуурмаг үнэлэмжүүд хэрэггүй. Ариун бус хүн чанар гэдэг бол хүний “ressentiment”-ийн бүтээл гэдгийг хэлж болохоор байна”⁷ гэж өгүүлжээ. Ариун бус зан авир хүнээс яагаад гардаг вэ? Өөрөөр хэлбэл “эзнийг хорлох” тухай бодол, энэ нь хүний эрхээр хорсол гомдолтой амьдарсантай холбоотой илэрдэг сэтгэл зүйн байдал мөн. Ф.Ницшегийн үзсэнээр гагцхүү “Over man” буюу үлэмж хүн л даасан эрх чөлөөтэй байдаг. Эрх чөлөөт хүн л өөрийн ёс суртахуунаар “сайн”-ыг үйлдэх боломжтой гэжээ.

Ф.Ницше эзэн, боолын ёс суртахууны жишээгээр түүхэнд бий болж ирсэн дарангуйлах ёс, түүний эсрэг тэмцлийг өгүүлэхийн зэрэгцээ хүмүүнлэг, эрхэм чанарын тухай бас дурдсан. Түүний бичсэнээр “...хүн гэдэг амьтан үүрэг хариуцлагын мэдрэмжтэй байдаг, түүний үг ба үйлдлүүд анхнаасаа зөөлөн арга замаар явагдаагүй, харин ч хатуу ширүүн, догшин, шийтгэх арга хэмжээтэй

⁷ Ф.Ницше. К генеалогии морали- Сочинения в двух томах. Т.1, М., 1990, с. 233.

тулгардаг.⁸ Тийнхүү хүнд төрөлхийн зан суртахууны эрхэм чанар байх боловч, нийгмийн харилцааны явцад эрхэм чанараа алдсан гэж үзэж байв. Ийм тул европ хүний хувьд ёс суртахууны үүсэл хүнээс өөрөөс нь хамаарахгүй, нийгэм-соёлын тогтолцоо, түүхэн туршлагаар нөхцөлдөж ирсэн гэжээ. Тэрээр хувь хүний бие даасан байдлыг зан суртахуунд хамааруулан үзсэн. “Ёс суртахууны эрхэм дээд үйлдлийг бид байгалийн мөн чанараар тайлбарлах боломжтой, ямар нэг зан заншлын хэмжээст баригдаагүй, зүгээр л бидний өөрийн мэдрэмж. Ёс суртахууны ойлголт бол дэлхийн түүх гэж бидний нэрлэдэг өмнөх өдрүүд, түүхэн цаг хугацааны шийдвэр бөгөөд энэ нь тодорхой бүлгийн эрх мэдэл, ашиг сонирхлоос гаралтай юм”⁹ гэсэн. Хүний зан суртахууны эрхэм чанар бол хүнд өөрт нь байгаа зүйл, хүний өөрийнх нь эрх чөлөөт байдлын илэрхийлэл болдог бөгөөд хүн ямар нэг дарамт шахалтгүй, өөрийн мөн чанараараа байх нөхцөлд л хүнээс ёс суртахууны сайн чанаруудыг харж болно гэдэг.

Түүний бичсэнээр “...бие даасан, эрх чөлөөт хувь хүн чухал үүргийг гүйцэтгэгчийн хувьд өөрийгөө зохицуулах чадвартай амьтан. Энэ бол хүнээс авах боломжгүй, түүний зарим төгс байдал, шууд мэдрэмж”¹⁰ гэжээ. Ийнхүү хүнд өөрт байгалиас заяасан зан суртахууны эрхэм дээд чанар байгаа л юм бол энэ нь гагцхүү хувь хүний хэнээс ч, юунаас ч хараат бус эрх чөлөөнд илрэх боломжтой гэсэн байна. Энэ бол “Over man- үлэмж хүн”-ий тухай ойлголттой холбоотой.

Уламжлалт нийгмүүдэд “Over man- үлэмж хүн” байгаагүй, Учир нь “Христ шашинт нийгэмд гомдлын мэдрэмж бүрнээ айдас, дуулгавартай байх зарчмаар солигдсон. Ийм замаар тогтсон ёс суртахууны загварыг дуулгавартай дагаж, түүнээс гажих нь айдас хүйдэст автсан “хүн

сүрэг” бий болсон” гэж Ф.Ницше үзжээ. “Хүн сүрэг” гэдэг зүйрлэл бол нийгмийн хэм хэмжээг даган мөрддөг, бусадтайгаа адилхан байхыг зорьдог бөгөөд бусдаас ялгарахыг хүсдэггүй, ялгарах гэхэд айдаст автдаг тийм хүмүүст хамаардаг. Ийм айдас өдгөө ч бидний үл ухамсарлахуйд уламжлан хадгалагдсан байж болох юм. Тухайлбал хурал, нийтийн цуглаан дээр нийтлэг хэм хэмжээнд харшлах зүйл ярьчихвал байгууллагад “муу хүн болчих вий”, “үнэн”-ийг дурдвал “гадуурхагдах вий” гэсэн далд айдас байсаар л байдаг.

Ёс суртахууны уг гарал нь нийгмийн тодорхой бүлгийн явцуу ашиг сонирхлоос эх сурвалжтай болох тухай Ф.Ницше “Ёс суртахууны түүх бол төөрөгдлийн түүх, энэ нь ээлжлэн солигдсон үүрэг хариуцлага гэгч төөрөгдлийн түүх юм”¹¹ хэмээн тэрээр үзжээ. Европ хүний ёс суртахууны генеалогийг судалсан Ф.Ницшегийн үзэл санааг бүхэлд нь харвал тэрээр эзэд, сурвалжтан хүний ёс суртахууны генеалогийг өөрийн ноёрхлоо хамгаалсан ашиг сонирхлоос эх сурвалжтай, нийгмийн ийм сурвалжит давхрааны ёс суртахуун нь цаашлаад нийгмийн тогтолцоог тодорхойлдог гэж үздэг. Үүний дараа “ressentiment” гэдэг ойлголтоор гомдол, гэм буруугийн мэдрэмж зэрэг нь сул доройчуудын ёс суртахууныг илэрхийлдэг.

Энэ хоёр ёс сурт ахууны аль, аль нь хүний эрхэм чанар, инстинктив мэдрэмжээс эх сурвалжтай биш учир гажуудсан ёс суртахууны хэлбэр гэж тэрээр үздэг. Ф.Ницше хүний төрөлх эрхэм чанарыг илэрхийлдэг зан суртахуун хүнд өөрт нь байдаг. Энэ нь гагцхүү хувь хүний бие даасан чөлөөтэй байдалд хэрэгжих боломжтой гэж субъектив мэдрэмжид ач холбогдол өгсөн байна.

Ф.Ницшегийн боловсруулсан ёс суртахууны генеалогийн үүднээс харвал

⁸ Ф.Ницше. К генеалогии морали- Сочинения в двух томах. Т.1, М., 1990, с. 428.

⁹ Мөн гэнд. с. 432.

¹⁰ Ницше. К генеалогии морали- Сочинения в двух томах. Т.1, М., 1990, с. 435-436.

¹¹ Ф.Ницше. Эмгэнэлт жүжгийн үүсэл буюу эллин ёс ба гутрангуй үзэл. Христэд тэрслэгч. Орч. О.Чимэг, УБ., 2012, 267 дахь тал.

ёс суртахуун ямар байх ёстой гэдэг нь объектив бодит агуулгагүй, түүхэнд тогтсон онол мэдлэгээр хэрхэн утга оруулж, хэрэглэж байгаагаар тодорхойлогддог. Иймээс ёс суртахуун бол үнэлэмжийн шинжтэй. Хүний жам ёсны бодит нөхцөлд ч харшлах зүйлийг шударга хэмээн үзэж болдог. Тухайн түүхэн цаг үед хувь хүн бүр хүссэн, хүсээгүй оршин буй нийгмийн ёс суртахууны хэм хэмжээнд захирагддаг. Энэхүү европын түүх-соёлын туршлагаас ангид хүний ёс суртахууныг төсөөлөх боломжгүй байсаар ирсэн болохыг өөрийн бүтээлдээ авч үзсэн. Өөрөөр хэлбэл, европ хүний ёс суртахууны уг гарал нь тухайн түүх-соёлынхоо нөхцөлтэй нягт холбоотой бий болжээ. Гэхд ээ гол асуудал нь Ф.Ницше ийм ёс суртахууныг “гажуудсан” хэмээн шүүмжилсэнд оршино. Түүний байр сууриар бол эрх чөлөөт хүний ёс суртахууны үнэт чанарууд түүх соёлынхоо мөн чанараар нөхцөлдсөн бус, харин хүний өөрийнх нь инстинктив үзэгдлүүд байх ёстой гэсэн агуулгатай юм.

Дүгнэлт

Хүн төрөлхтний түүхэн нөхцөл дэх эрх, эрх чөлөөний хязгаарлагдмал байдал, ёс суртахууны харьцангуй ойлголтын тухай Ф.Ницше өөрийн бүтээлдээ нэн тодорхой өгүүлжээ. Ф.Ницшегийн үзлээр, эдүгээгийн хүн бол бүрэн боловсорч гүйцээгүй амьтан бөгөөд амьтан-хүн хоорондын дамжлага маягийн зэрэмдэг зүйл гэдэг. Ийм зэрэмдэг хүний зэрэмдэг ёс суртахууны тодорхой илрэл бол боолын болон христ шашны ёс суртахуун гэж тэрээр зүйрлэн өгүүлсэн. Ф.Ницше хүнийг “зэрэмдэг хүн” хэмээн доромж байдлаар үзсэн мэтээр буруушаах нь бий. Өөрийнхөөрөө орших эрхгүй, өөрийнхөөрөө сэтгэх боломжгүй оюун санааны эрх чөлөөгүй, айдаст автсан тийм хүнийг ийнхүү ойлголтоор илэрхийлжээ. Нэг талаас хүн төрөлхтний туулж ирсэн нийгмийн нөхцөлийг Ф.Ницше өөрийн бүтээлээр харуулсан байна. Энэ нь хүн өөрийн бүтээж ирсэн түүхэн цаг үе бүхэнд нэг хэсэг нь нөгөөгөө эрхшээсээр жинхэнэ

мөн чанараа олж чадаагүй гэсэн утгыг илэрхийлэх болов уу.

Нэг хэсэг цөөнх нь олонхоо захирч, ноёрхсон түүхийн урт хугацаанд хүмүүсийн ихэнх нь ямар нэг айдастай, гомдолтой байсаар ирсэн. Учир нь тэдний эрх янз бүрээр зөрчигдсөөр, эрхэмлэх зүйл, эрхэм чанараа алдсаар байжээ. Ийнхүү айдаст автсан олонход хэзээ ч ёс суртахууны үнэн мөн чанар гэж байгаагүйг тэрээр ойлгож байсан. Ф.Ницше; хүн төрөлхтөн өөрийн ёс суртахууны үнэт зүйл гэх хэмжүүрийг задлан шинжилж, дагаж мөрдөж ирсэн ёс суртахуунд шүүлтүүр тавих шаардлагатай гэдгийг онцолсон юм. Тухайн ёс суртахууны үнэт зүйлийн шалгуур нь хүн төрөлхтний амьдралын хэв маягт нийцэж байна уу, үгүй юу? Илүү хүчирхэг хүн төрөлхтөн бий болоход нөлөөлөөд байгаа юм уу, эсвэл бүлэг хүмүүсийн илүү удаан оршин тогтнох хувийн ашиг сонирхлыг хамгаалах хэрэгсэл болоод байгаа юм уу гэдгийг шалгах ёстой. Ийм мэдлэгийн шалгуур өнөөг хүртэл гараагүй. Эдгээр үнэт зүйлсийн үнэлэмж үргэлж өгөгдөл, (байх ёстой зүйл мэт) тогтсон таалал байдлаар ойлгогддог байсан нь ёс суртахууныг гажуудалд хүргэсэн гэдгийг Ф.Ницше өөрийн бүтээлдээ гаргаж тавьсан.

Тэрээр, европын нийгэмд мөрдөж ирсэн ёс суртахууны үнэт зүйлс үнэндээ муу байсан бол яах вэ?,” гэдэг асуулт тавьж, ёс суртахуун гэдэг зүйл яагаад, яаж, хэрхэн бүрэлдсэн бэ, түүний үүсэл гарлыг хаанаас эрэх ёстой вэ гэдэг асуудлыг хөндсөн нь сонирхолтой, бөгөөд онцлог агуулгатай байдаг. Өөрөөр хэлбэл юуг ёс суртахуунтай, юуг ёс суртахуунгүй гэж үзэх вэ гэдэгт анхаарлаа хандуулж, тогтсон таалал байдлаар уламжилж ирсэн ёс суртахууны шаардлагуудыг “үнэн”- ний шалгуураар шүүн хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн юм. Өнө удаан хугацаанд ёс суртахууны сайн чанар хэмээн үнэлж ирсэн шаардлагууд үнэндээ хувь хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхол, хөгжил хөдөлгөөнд

харшилж, саад тотгор болж байвал яах вэ гэдгийг дэвшүүлсэн нь ихээхэн ач холбогдолтой юм.

Хүний ёс суртахууны сайн чанарууд нийгэм соёлын хэм хэмжээгээр нөхцөлдөж төлөвшихөөс гадна, субъектив агуулгатай, хүнд өөрт нь өгөгдмөл байдаг гэж үзсэн нь өвөрмөц юм. Хүнд төрөлхийн хайрлах, өрөвдөх, гэмших дотоод мэдрэмжүүд гэж бий. Энэ өгөгдмөл мэдр эмж нь аливаа харилцан үйлчлэлийн явцад ёс суртахуунлаг, хүмүүнлэг үйлдлээр илэрч байдаг. Гагцхүү яагаад хүн харгис зан чанар, өс хонзон, хорлонт сэтгэл тээдэг вэ гэвэл тэр гомдсон, зовсон, хагацсан эрх нь зөрчигдсөн. Энэ үед сайн чанаруудаа үгүй хийж муу зан авир илрэн гарч ирдэг гэж үзэж болно. Энэ утгаар “хүн ямар нэг хэмжээс, айдас, дарангуйлалд бус, өөрөөрөө, өөрийн мөн чанараараа орших тэр нөхцөлд ёс суртахууны жинхэнэ үнэт зүйлүүдийг түүнээс хайж болно” гэсэн Ф.Ницшегийн үзэл баримтлалд зөвтгөх үүднээс хандаж байна.

Ном зүй

Монгол хэл дээр

1. Ф.Ницше. Эмгэнэлт жүжгийн үүсэл буюу эллин ёс ба гутрангуй үзэл. Христэд тэрслэгч. Орч. О.Чимэг, УБ., 2012.
2. С.Хишигтогтох. Ухамсаргүйн тухай З.Фрейдийн үзэл соёлын генеалогид холбогдох нь. Философийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээл. УБ., 2019.

Орос хэл дээр

1. Ф.Ницше. К генеалогии морали. – Ф.Ницше. Сочинения в двух томах. Т.1, 1990.

Abstract: *The question of the origin and nature of morality is one of the key issues in the study of philosophy and ethics. Because morality is a complex and broad concept of an individual and the social intelligence. To understand the nature of morality, which is a valuable personal and social asset, it is essential to study its origins. Is morality natural in its origin? Is morality, in essence, just a mental phenomenon?*

In our article, we explain how morality is not only a mental phenomenon, we consider the concept of F. Nietzsche, which explains morality in terms of human nature. Factors influencing the formation of morality can be divided into two groups: social factors (economic, political, social structure, culture, etc.) and personal factors (behavior, attitudes, moods, etc.). The concepts of morality is different. On the one hand, morality is a normative system that is shaped by social historical and cultural experience, that regulates social relations. Morality, on the other hand, is a manifestation of human behavior, which is a human virtue. F. Nietzsche explained the origin of morality in relation to the nature of the individual. In other words, norms that are assessed as “right”, “good”, or “moral” for a given society or culture may be “wrong”, “bad, or immoral” in the interests of the individual. Here, the moral concepts of what is “true,” “right,” and “fair” are determined by the nature of society at the time.